# ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## /2021-2024 ОН/

*Төлөвлөгөөг баталсан:* *Төсвийн Ерөнхийлөн захирагч*

***МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД*** ***С.АМАРСАЙХАН***

*2021 оны ... дугаар сарын ....-ны өдөр*

*Төлөвлөгөө боловсруулсан:* *Төсвийн шууд захирагч*

***ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ*** ***Г.АРИУНБУЯН***

*2021 оны ... дугаар сарын ....-ны өдөр*

**УЛААНБААТАР ХОТ**
**2021 ОН**

## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА


**1. Нийтлэг үндэслэл**

**2. Мандатын шинжилгээ**

**3. Байгууллагын алсын хараа**

**4. Байгууллагын эрхэм зорилго**

**5. Орчны шинжилгээ**

**5.1. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд хийсэн гадаад, дотоод орчны шинжилгээний үр дүн**

**6. Стратегийн зорилго, зорилт**

**7. Стратеги, түүний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин**

**8. Нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал**

**9.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо**

**9.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт**

**9. Хавсралт**

**9.1. Онцгой байдлын ерөнхий 2021-2024 оны төсвийн төсөөлөл**

**9.2. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд нийтлэг мөрдөгдөж байгаа хууль**

**9.3. Онцгой байдлын байгууллагын хамтын ажиллагаа**

**9.4. Байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээ**

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс ирэх 30 жилийн хөгжлийн бодлогоо тодорхойлж, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг, түүнтэй нийцүүлэн УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг, 24 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан.

Төрийн албаны тухай хуулийн 53.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасан.

Онцгой байдлын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхийн тулд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан Онцгой байдлын байгууллагаас ирэх 4 жилд баримтлах үйл ажиллагааны зорилго, чиглэл, арга замуудыг тодорхойлох шаардлага гарч байна.

Иймд Засгийн газрын 2019 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар”-ыг үндэслэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”-т дэвшүүлсэн зорилго, зорилтод нийцүүлэн “Онцгой байдлын ерөнхий газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 5 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ, Онцгой байдлын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 38 арга хэмжээ, төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 4 зорилтын хүрээнд, 19 арга хэмжээг ирэх 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэхээр боловсруулсан болно.

Дээрх зорилт, арга хэмжээг нийлүүлэхдээ хүн хүч, хөрөнгө санхүүгийн нөөцийг хамгийн оновчтой байдлаар хуваарилан зарцуулж, дэвшүүлсэн зорилтуудын эцсийн үр дүнг хангахаар тооцсон болно.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатын шинжилгээг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор онцгой байдлын байгууллагад хуулиар олгосон чиг үүргийг хамруулан дараахь гурван алхамын хүрээнд хийлээ. Үүнд:

1. Хууль тогтоомжоос Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
3. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдох талуудын оролцоог тодорхойлох.

| | | |
|---|---|---|
| Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 30 |
| Үүнээс: | Тухайн салбарын хуулийн тоо | 3 |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | 21 |

**Ерөнхий чиг үүрэг 1:** Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах

| **Үндсэн чиг үүрэг** | **Дэд чиг үүрэг** | **Холбогдох оролцогч талууд** |
|---|---|---|
| 1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа | Гамшгийн эрсдэлийг бууруулах | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хувийн хэвшил, иргэд |
| | Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хувийн хэвшил |
| | Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хувийн хэвшил, иргэд |
| | Гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| | Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах | Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, иргэний нийгмийн байгууллага |
| | Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх | Төрийн болон иргэний нийгмийн байгууллага, гамшгаас хамгаалах алба |
| 2. Гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаа | Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах | Төрийн цэргийн байгууллага, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, гамшгаас хамгаалах алба, хувийн хэвшил |
| | Гамшгийн голомтын бүсийг тогтоох | Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, гамшгаас хамгаалах алба |
| | Гамшгаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах | Бүх шатны онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэд |
| | Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг дайчлан гаргах, | Бүх шатны онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, |

| | | |
|---|---|---|
| | нүүлгэн шилжүүлэх | сайн дурын хэсэг |
| 3. Хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах | Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах | Бүх шатны онцгой комисс, олон улсын хүмүүнлэгийн кластерын баг |
| **Ерөнхий чиг үүрэг 2:** Галын аюулгүй байдлыг хангуулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, улсын хяналтыг хэрэгжүүлэх | | |
| **Үндсэн чиг үүрэг** | **Дэд чиг үүрэг** | **Холбогдох оролцогч талууд** |
| 1.Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, улсын хяналыг зохион байгуулах | 1.Объектын болон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах, | Байгаль орчин, аялал жуулчлалын яам,<br>Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл<br>Иргэний нийгмийн байгууллага |
| | 2.Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх | - |
| | 3.Гал түймрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, гал түймрийн шалтгаан, нөхцөлийг судлах, судалгаа, шинжилгээ хийх, | Төрийн болон иргэний нийгмийн байгууллага |
| | 4.Галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж, мөрдүүлэх | Барилга, хот байгуулалтын яам,<br>Эрчим хүчний яам<br>Стандарт, хэмжил зүйн газар |
| 2.Гал түймрийг унтраах үйл ажиллагаа | 1.Объектын болон ой, хээрийн гал түймрийг унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах | Бүх шатны онцгой комисс<br>Гал унтраах сайн дурын хэсэг |
| **Ерөнхий чиг үүрэг 3:** Гамшгийн үеийн нөөцийн бэлэн байдлыг хангах | | |
| **Үндсэн чиг үүрэг** | **Дэд чиг үүрэг** | **Холбогдох оролцогч талууд** |
| 1. Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх | 1.Нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх ажлыг зохион байгуулах, дотоодын хяналт тавих | Сангийн яам<br>Шадар сайдын ажлын алба<br>Гамшгаас хамгаалах алба |
| | 2.Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх, тайлагнах | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар<br>Сангийн яам<br>Улсын онцгой комисс<br>Шадар сайдын ажлын алба |
| | 3.Гэрээт хадгалагчтай гэрээ байгуулж, нөөцийн бараа, материал хадгалах үйл ажиллагаанд нь хяналт тавих | Гэрээт аж ахуйн нэгж, байгууллага |
| **Ерөнхий чиг үүрэг 4:** Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх | | |
| **Үндсэн чиг үүрэг** | **Дэд чиг үүрэг** | **Холбогдох оролцогч талууд** |
| 1.Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх | 1.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах | Төрийн албаны зөвлөл |

| | | |
|---|---|---|
| | 2.Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах | Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар |
| 2. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх | 1.Гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Шадар сайдын ажлын алба<br>Гамшгаас хамгаалах алба |
| | 2.Гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх | Төрийн болон иргэний нийгмийн олон улсын байгууллага, хувийн хэвшил, гадаад улс орон |
| 3.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах | 1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх | Хэвлэл мэдээллийн байгууллагууд |
| 4.Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх | 1.Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах | Сангийн яам, олон улсын байгууллага, хувийн хэвшил |
| | 2.Ар тал хангалт, үйлчилгээг зохион байгуулах | |
| 5. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг зохион байгуулах | 1.Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх, дотоод аудит хийх | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар<br>Шадар сайдын ажлын алба |

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА

Үндэсний болон олон улсын хэмжээнд итгэл хүлээсэн, үйл ажиллагааны чадавхтай байгууллага болон хөгжихөд оршино.

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

5.1. Онцгой байдлын байгууллагын бодлогын баримт бичигт тусгасан зорилт болон хуулиар ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчин зэрэг гадаад орчны зүгээс үзүүлэх нөлөөлөл, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, соёл, нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл) хийгээд технологийн үйл явцын талаар дотоод

орчны зүгээс үзүүлэх давуу болон сул талыг тодорхойлж /Хавсралт 9.4/ үр дүнг дараахь хүснэгтэд нэгтгэв.

**Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд хийсэн гадаад, дотоод орчны шинжилгээний үр дүн**

| **Дотоод орчин** | |
|---|---|
| **Давуу тал** | **Сул тал** |
| • 21 аймаг, нийслэл, дүүрэгт гамшгаас хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулах салбар нэгжтэй.<br>• Төрийн цэргийн байгууллагын хувьд байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, хүний нөөцийн тогтвортой байдал хангагдсан.<br>• Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратегиа тодорхойлсон.<br>• Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүний болон санхүү, техник, технологийн нөөц тодорхой хэмжээнд бүрдсэн.<br>• Гамшгаас хамгаалах мэргэжилтэй боловсон хүчнийг гадаад, дотоодод бэлтгэдэг.<br>• Төр засгийн дэмжлэг, иргэд, олон нийтийн дунд нэр хүнд сайтай.<br>• Гамшгаас хамгаалах, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хууль, эрх зүйн орчин боловсронгуй болсон.<br>• Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж байгаа.<br>• Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжсөн. | • Гал унтраах, эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн хүртээмж хангалтгүй.<br>• Орон тооны дээд хязгаарыг Засгийн газраас баталдаг учраас шаардлагатай орон тоог нэмэх боломж хязгаарлагдмал байдаг.<br>• Байгууллагын үйл ажиллагаа улсын төсвөөс хамааралтай тул батлагдсан төсөв хүрэлцдэггүй, үүнээс шалтгаалж зарим төлөвлөсөн ажил тасалдах, дутуу биелэх зэрэг сөрөг нөлөө гардаг.<br>• Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл хангалтгүй.<br>• Аливаа ажил тушаал шийдвэрээр явагддаг тул албан хаагчдын идэвх санаачилга сул.<br>• Өндөр боловсролтой, мэдлэг чадвартай боловсон хүчин шинээр ажилд орох магадлал бага.<br>• Байгууллагын үйл ажиллагаа дүрэм, журамд баригддаг тул өөрчлөлт хийх, хүлээн авах сонирхол, хүсэл эрмэлзэл бага.<br>• Албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийн түвшин хангалтгүй, тэдний суржхөгжих хүсэл эрмэлзэл, идэвх сул. |
| **Гадаад орчин** | |
| **Боломж** | **Эрсдэл** |
| • Төр засгийн дэмжлэг, иргэд олон нийтийн итгэл, оролцоог нэмэгдүүлэх<br>• Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог улам боловсронгуй болгох.<br>• Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон улсын зээл, тусламж, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. | • Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн аюулын тоо, давтамж, учруулах хохирол жил бүр нэмэгдэж байгаа.<br>• Урьдчилан тооцоогүй шинэ төрлийн гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаа.<br>• Улс орны эдийн засгийн чадавх сул тул төсвийн хөрөнгө мөнгө хязгаарлагдмал.<br>• Улс орны нийгмийн байдал харилцан |

| | |
|---|---|
| • Хүн амын өсөлт, амьдралын хэв маяг, амьжиргааны түвшин, хот суурин газрын хөгжилтэй уялдуулж, үйл ажиллагаагаа төлөвлөж явуулах.<br>• Уур амьсгал, байгаль цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бий болгох, байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаг оновчтой зохион байгуулах.<br>• Гамшгаас хамгаалах даатгалын тогтолцоо, эрх зүйн орчинг боловсронгуй болго.х<br>• Орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах.<br>• Хот төлөвлөлт, барилга байгууламжийн стандарт, норм дүрэм, журмыг боловсронгуй болгох.<br>• Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаг дэмжих, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.<br>• Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээг өргөжүүлэх, шинэ техник технологийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд нэвтрүүлэх. | адилгүй, ажилгүйдэл, ядуурлын түвшин буурахгүй байна.<br>• Замбараагүй хот төлөвлөлт, хүн амын хэт төвлөрөл, гэр хороолол нэмэгдэж байгаа нь гамшгийн эрсдэлийг дагуулж байна.<br>• Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг ойлголт, хандлага сул.<br>• Малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн доройтол, уур амьсгалын өөрчлөлт нь хөдөө аж ахуйн салбарт сөргөөр нөлөөлж байна.<br>• Улс орны төсвийн ихэнх хэсгийг дан ганц уул уурхайн салбар бүрдүүлж байгаа нь эдийн засгийн чадавх, хүн амын орлого, амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байна. |

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

6.1.Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах техник тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулж, бэлэн байдлыг дээшлүүлэх.

6.2.Стратегийн зорилго, бодлогын баримт бичигт туссан зорилт, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр дараахь зорилтыг дэвшүүлж ажиллана:

| **1. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ** | |
|---|---|
| **Зорилт 1.** | Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулах |
| **Зорилт 2.** | Онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах |
| **Зорилт 3.** | Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх |
| **2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА** | |
| **Зорилт 4.** | Гамшгийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, гамшиг судлалын шинжлэх ухаан, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх |
| **3. ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА** | |

| | |
|---|---|
| **Зорилт 5.** | Гамшгийн нэгдсэн удирдлага зохицуулалтыг сайжруулах, холбоо, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах |
| **Зорилт 6.** | Хөвсгөл нуурт живсэн машин, техникийг татан гаргах ажлыг олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах |
| **3. ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, УНТРААХ, УЛСЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | |
| **Зорилт 7.** | Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах |
| **Зорилт 8.** | Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах |
| **5. ГАМШГИЙН ҮЕИЙН НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ** | |
| **Зорилт 9.** | Стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах |
| **Зорилт 10.** | Улсын нөөцийн удирдлага, зохион байгуулалт, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулалтыг сайжруулах |
| **6. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | |
| **Зорилт 11.** | Удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх |
| **Зорилт 12.** | Гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бүх талын хамтын ажилллагааг хөгжүүлэх |
| **Зорилт 13.** | Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ар тал, хангалт үйлчилгээг сайжруулах |
| **Зорилт 14.** | Дотоод аюулгүй байдлыг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг дээшлүүлэх, |

# ДОЛОО. СТРАТЕГИ, ТҮҮНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН

| Бодлогын баримт бичигт тусcан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 1: ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛЖ, МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ** | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг 1: Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа** | | | | | | | |
| **Зорилт 1.** Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн стандартын түвшин, хангалтыг дээшлүүлж, гамшгийн үеийн харилцаа холбоог сайжруулах | 1.1. Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Онцгой байдлын албанд гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх | Гал унтраах тусгай зориулалтын 42 ш автомашин нийлүүлэгдэнэ. | Гал түймэр унтраах аврах ангийн автомашины хангалт 501 байхаас 260 буюу 51,8%-ийн хангалттай байна | 2022 онд нийт тусгай зориулалтын гал түймэр унтраах автомашины тоо 302 болж хангалт 63%-д хүрнэ | 2021-2022 | БНФУ-ын Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө – 14.9 сая евро | БЗХАГ ГТТГ |
| | 1.2.АХБ-ны санхүүжилтээр “Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээллэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь” техник-туслалцааны төслийг хэрэгжүүлэх | -Гамшгийн аюулын зарлан мэдээллийн системийн өнөөгийн нөхцөл байдлын нарийвчилсан судалгаа<br>-Телевиз, үүрэн холбооны сүлжээний хэрэглэгчдэд хүргэх зарлан мэдээллийн системийн техникийн шийдэл | Төсөл хэрэгжүүлэх албан захидалд АХБ, Сангий яам, ОБЕГ 2020.07.22-нд үсэг зурсан | 2021 онд газар нутаг, хүн ам зүйн онцлогт тохирсон гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн системийн зураглал болон ТЭЗҮ боловсруулагдана. | 2021 | Азийн хөгжлийн банк – 550,000 ам.доллар Японы ядуурлыг бууруулах сан - 500,000 ам.доллар Нийт 1,050,000 ам.доллар | ГШУГ БЗХАГ |
| | 1.3.АХБ-ны санхүүжилтээр “Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээллэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь” зээлийн төслийг хэрэгжүүлэх | -Онцгой байдлын анги, байгууллагын өндөр хурдны нэгдсэн сүлжээ<br>-Кабелийн болон IP телевизээр зарлан мэдээлэл дамжуулах дэд систем<br>-Онцгой байдлын байгууллагын тоон | Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн системийн зураглал болон ТЭЗҮ | Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв, 5 бүсийн болон 21 аймгийн зарлан мэдээллийн төвүүдийг холбосон зарлан мэдээллийн нэгдсэн системтэй болсон байна. | 2021-2024 | Азийн хөгжлийн банкны зээл – 30 сая ам.доллар, буцалтгүй тусламж – 3 сая ам.доллар Нийт 33 сая ам.доллар | ГШУГ БЗХАГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | технологи<br>-Аймаг, сумдад зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхагууд | | | | | |
| | 1.4.“Онцгой байдлын байгууллагын гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлэх” төсөл хэрэгжүүлэх | -Төслийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газар хоорондын гэрээ,<br>-Төслийн санхүүжилт<br>-55 нэгж техник<br>-Засварын төв | Төслийн саналыг боловсруулж, Сангийн яам болон БНХАУ дахь Монголын Улсын элчин сайдын яаманд хүргүүлсэн. | -Төслийн хүрээнд 55 нэгж машин механизм нийлүүлэгдэнэ.<br>-Машин механизмын граж, иж бүрэн засварын төв байгуулагдана. | 2021-2023 | 5.5 сая ам доллар | БЗХАГ |
| **Зорилт 2.**<br>Онцгой байдлын байгууллагад агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах | 2.1.“Онцгой албанд агаараас аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх | -Агаараас эрэн хайх, аврах нэгж<br>-4 ш нисдэг тэрэг<br>-Бэлтгэгдсэн хүний нөөц<br>-Ангар, сургалтын байгууламж | ОБЕГ-ын Агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах тухай Засгийн газрын тогтоол 2020 оны 10 дугаар сард гарсан | Агаараас эрэн хайх, аврах нэгж нь батлагдсан бүтэц, орон тооны дагуу байгуулагдана.<br>-ЕС-145 маркийн 3 нисдэг тэрэг, Cabri маркийн сургалтын нисдэг тэрэг-1ш, симулятор-1ш нийлүүлэгдэж, ангар болон сургалтын байгууламж баригдана.<br>-2024 он гэхэд Агаараас эрэн хайх, аврах нэгжийн үйл ажиллагаа жигдэрсэн байна. | 2021-2024 | БНФУ-ын Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө – 43 сая евро | БЗХАГ<br>ЗУГ<br>ГШУГ |
| | 2.2.Агаараас эрэн хайх, аврах ажиллагааны дүрэм, журам, заавар, стандарт боловсруулж батлуулах | -Агаараас эрэн хайх, аврах ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар, стандарт | - | -Агаараас эрэн хайх, аврах чиглэлээр дүрэм, журам, заавар, стандарт боловсуулж батлагдана. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГШУГ |
| | 3.1.Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөр боловсруулж батлуулах | Гамшгаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр | Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө” ОБЕГ-ын даргын 2016 оны А/130 дугаар тушаал | -Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд ГСХ-ээр захиалгат судалгааны ажил хийлгэнэ.<br>-Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөр боловсруулж Шадар сайдын тушаалаар батлуулна. | 2021-2022 | Үйл ажиллагааны зардлаар | ГУСГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3.** Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх | 3.2.Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын бocго стандартыг боловсруулж батлуулах | Хүүхэд хамгааллын бocго стандарт | "Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэл". ОБЕГ-ын даргын 2014 оны А/245 дугаар тушаал | -Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Японы Хүүхдийг ивээх сантай хамтран ажиллах талаар хэлэлцэнэ.<br>-Стандартыг боловсруулж ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулна. | 2021-2022 | Үйл ажиллагааны зардлаар | ГУСГ |
| | 3.3.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль (ИБС) болон Команд штабын сургууль (КШС) зохион байгуулах | Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль | 2020 онд Нийслэл, Говьсүмбэр аймагт ИБС, Дундговь аймагт КШС зохион байгуулсан. | -2021 онд Орхон, Сэлэнгэ аймагт ИБС, Баянхонгор, Өвөрхангай аймагт КШС,<br>-2022 онд Дархан-Уул, Дорнод аймагт ИБС, Баян-Өлгий, Өмнөговь аймагт КШС,<br>-2023 онд Архангай, Булган аймагт ИБС, Говь-Алтай, Хөвсгөл аймагт КШС,<br>-2024 онд Дундговь аймагт ИБС, Увс, Сүхбаатар, Ховд аймагт КШС тус тус зохион байгуулна. | 2021-2024 | Орон нутгийн төсөв 113.0 сая төгрөг | ГУСГ |
| | 3.4.Өмнөд бүсийн төвийг түшиглэн Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв байгуулах | -Сургалтын төвийн зураг, төсвийг тооцоо<br>Сургалт, арга зүйн төв | - | 2024 онд Сургалтын төвийн гүйцэтгэйиг 100 % хүргэж ашиглалтад оруулна | 2021-2024 | Улсын болон орон нутгийн төсөв 5.0 тэрбум төгрөг | ГУСГ Өмнөд бүсийн төв |
| | 3.5.Онцгой байдлын байгууллагын хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх хэвлэл, мэдээллийн инфо сүлжээ байгуулах | -Гамшгаас урьдчилан сэргийлэх хэвлэл, мэдээллийн инфо сүлжээ | - | 2024 онд Инфо мэдээллийн сүлжээ бий болгох, телевизийн шууд дамжуулалт явуулах нөхцөлбүрдсэн байна. | 2021-2024 | Улсын болон орон нутгийн төсөв | ГУСГ |
| | 3.6.Гамшгаас хамгаалах сургалтыг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан | Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын тоо | -Удирдах албан тушаалтны 71, оюутан, сурагчдын 108, албан тушаалтан, ажилтны 492, гамшгаас | Жилд дунджаар удирдах албан тушаалтны 120, оюутан, сурагчдын 300, албан тушаалтан, ажилтны 500, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 300, иргэдийн | 2021-2024 | Орон нутгийн төсөв | ГУСГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тушаалтан, ажилтан, иргэдэд зохион байгуулах. | | хамгаалах алба, мэргэжлийн ангийн 204, иргэдийн 264 удаагийн сургалт зохион байгуулсан. | 400 удаагийн сургалт зохион байгуулна | | | |
| | 3.7.Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг зохион байгуулах | Нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн удирдамж, тоо | Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу 6 удаагийн нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг зохион байгуулсан. | Өвөлжилт, хаваржилт,зуд, үер усны аюул, газар хөдлөлт, олон улсын иргэний хамгаалалт болон гамшгийн эрсдэлийг бууруулах өдөртэй холбогдуулан нийт 6 төрлийн удирдамжийг батлуулж, хэрэгжилтийг хангана. | 2021-2024 | Орон нутгийн төсөв | ГУСГ |
| | 3.8.Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуулийг улсын хэмжээнд зохион байгуулах | Нэгдсэн дадлага сургууль, хамрагдсан хүний тоо | 2019 онд Нэгдсэн дадлага сургуульд улсын хэмжээнд 838970 хүн хамрагдсан. | -Жил бүр улсын хэмжээнд хийгдэнэ.<br>-Нэгдсэн дадлага, сургуульд хамрагдсан хүний тоогоор хэмжигдэнэ. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГУСГ |
| **Үндсэн чиг үүрэг 2: Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа** | | | | | | | |
| **Зорилт 4.** Гамшгийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох, гамшиг судлалын шинжлэх ухаан, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх | 4.1.АХБ-ны санхүүжилтээр “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний чадавх, эрсдэл шилжүүлэх механизмыг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх | -Гамшгийн эрсдэлийн санхүүжилт, даатгалын нөхцөл байдлын үнэлгээ<br>-Гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн стратеги<br>-Гамшгийн даатгалын хуулийн төсөл | Төсөл хэрэгжүүлэх 5 бүсийн 13 аймгийг сонгосон | -Гамшгийн эрсдэлийн санхүүжилт, эрсдэлийн даатгалын нөхцөл байдлын үнэлгээ хийгдэнэ.<br>-Гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн стратеги болон төлөвлөгөө боловсруулагдана.<br>-Гамшгийн даатгалын хуулийн төсөл боловсруулагдана. | 2021 | Азийн хөгжлийн банк – 2,0 сая ам.доллар | ГЭУГ |
| | 4.2.Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг 2021-2025 онд хэрэгжүүлэх II дахь шатны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах | Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх II дахь шатны арга хэмжээний төлөвлөгөөний төсөл | Үндэсний хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө | Үндэсний хөтөлбөрийг 2021-2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлуулна. | 2021 | Үйл ажиллагааны зардлаар | ГЭУГ |
| | 4.3.Гамшгийн эрсдэлийг | Сендайн үйл | Сендайн үйл | Сендайн үйл ажиллагааны хүрээг | 2021 | Үйл | ГЭУГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг 2021-2025 онд хэрэгжүүлэх II дахь шатны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах | ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг 2021-2025 онд хэрэгжүүлэх II дахь шатны арга хэмжээний төлөвлөгөөний төсөл | ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг 2019-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг 2021-2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлуулна | | ажиллагааны зардлаар | |
| | 4.4.Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх | Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн зөвлөмжийн тоо | Үндэсний зөвлөлийн ажиллах журам<br>Үндэсний зөвлөлийн 2021-2022 оны эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны зөвлөмж | Үндэсний зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хагас, бүтэн жилээр дүгнэнэ.<br>Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн хуралдааныг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулж, дараа жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГЭУГ |
| | 4.5. Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд 4-өөс доошгүй гамшгийн төрлөөр эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх | 4-өөс доошгүй гамшгийн төрлөөр хийсэн эрсдэлийн ерөнхий үнэлгээ | 21 аймаг нийслэлийн хэмжээнд засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд ерөнхий үнэлгээ хийгдсэн. | Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн байна. | 2021-2024 | Орон нутаг болон олон улсын байгууллагын санхүүжилтээр | ГЭУГ |
| | 4.6.Улсын хэмжээнд ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн дотуур байранд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх | Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн барилгын хувь | Улсын хэмжээнд ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн дотуур байрны 20% гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн. | Улсын хэмжээнд ерөнхий боловсролын дунд сургууль, сургуулийн дотуур байрны 70%-д гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн байна. | 2021-2024 | Орон нутаг болон олон улсын байгууллагын санхүүжилтээр | ГЭУГ |
| | 4.7. Онцгой байдлын албаны хэмжээнд 1995 оноос өмнө баригдсан барилга, байгууламжид газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийх | Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн барилгын хувь | - | Улсын хэмжээнд нийт Гал унтраах, аврах ангийн 7 барилга, байгууламжид газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийсэн байна | 2021-2024 | Орон нутаг болон олон улсын байгууллагын санхүүжилтээр | ГЭУГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.8.Гамшиг судлалын хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Дунд хугацааны стратеги төлөвлөгөө хэрэгжилт 50% | Хэрэгжилтийг 100%-д хүргэж, 2025-2028 онд хэрэгжүүлэх ОББ-ын сургалт, эрдэм шинжилгээний нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | 2021-2024 | Улсын төсөв 1740,0 сая төгрөг | ГСХ ГЭУГ |
| | 4.9.Онцгой байдлын байгууллагын инновацын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Инновацын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Инновацын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 50% | Хэрэгжилтийг 100%-д хүргэж, 2025-2028 онд хэрэгжүүлэх Онцгой байдлын байгууллагын инновацын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно. | 2021-2024 | Улсын төсөв 500,0 сая төгрөг | ГСХ ГЭУГ |
| | 4.10.Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Бүтээмжийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөр ОБЕГ-ын даргын 2020 оны А/292 тушаалаар батлагдсан. | Хэрэгжилтийг 90%-д хүргэж шинэ санаа инновацын эх үүсвэр болгох, инновацын төслүүдийг боловсруулж эхэлнэ. | 2021-2024 | Улсын төсөв 70,0 сая төгрөг | ГСХ ГЭУГ |
| **Үндсэн чиг үүрэг 3: Гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаа** | | | | | | | |
| **Зорилт 5.** Гамшгийн нэгдсэн удирдлага зохицуулалтыг сайжруулах, холбоо, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах | 6.1.Орон нутгийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах | Бэлэн байдлын үзлэгийн тоо | Орхон, Өвөрхангай аймагт зохион байгуулсан | Жилд 1-2 аймагт тогтмол зохион байгуулна. | 2021-2024 | Орон нутгийн төсөв | ГШУГ, Орон нутаг |
| | 6.2.Гамшгаас хамгаалах улсын албаны бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах | Бэлэн байдлын үзлэгийн тоо | Хүнс, хөдөө аж ахуйн улсын алба, Сурталчилгаа мэдээллийн улсын албанд зохион байгуулсан. | Жилд 1-2 улсын албанд тогтмол зохион байгуулна. | 2021-2024 | Салбарын төсөв | ГШУГ, холбогдох яам, агентлаг |
| | 6.3.Гамшгаас хамгаалах улсын албаны Команд шатбын сургуулийг (КШС) зохион байгуулах | Команд шатбын сургуулийн тоо | Хөв журам сахиулах улсын албанд КШС зохион байгуулсан | Жилд 1 улсын албанд тогтмол зохион байгуулна. | 2021-2024 | Салбарын төсөв | ГШУГ, холбогдох яам, агентлаг |
| | 6.4.Усанаас эрэн хайх, аврах ажиллагааны зааварлагчийн сургалтыг зохион байгуулах | Сургалтын тоо | Усчин аврагчын дунд шатны усны сургалтын Хөвсгөл нууранд зохион байгуулсан | -Аврагч-усчны зааварлагч нарын сургалтыг Хөвсгөл нууранд,<br>-Аврагч-усчин, шумбагчийн түвшинг анхан шатаар бэлтгэх сургалтыг | 2021-2024 | Орон нутгийн төсөв | ЗУГ, ҮАБ, ДХИС, Орон нугийн ОБГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дорнод аймагт,<br>-Аврагч-усчин, шумбагчийн түвшинг дунд шатаар бэлтгэх сургалтыг Архангай аймагт<br>-Аврагч-усчин, шумбагчийн түвшинг дээд, гүнзгий шатаар бэлтгэх сургалтыг Хөвсгөл аймагт зохион байгуулна. | | | |
| | 6.5.Холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах | -Засвар үйлчилгээний график төлөвлөгөө<br>-Засвар үйлчилгээ хийсэн тоо | 838 техник хэрэгсэлд засвар үйлчилгээ, тохиргоо хийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан | Холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид жил бүр засвар үйлчилгээ хийж, бэлэн байдлыг хангана. | 2021-2024 | Улсын төсвөөс 60.0 сая төгрөг | ГШУГ |
| | 6.6.Холбоо, мэдээлэл хариуцсан оператор, Шуурхай удирдлагын оператор, жолооч-холбоочдын бүсчилсэн сургалтыг зохион байгуулах | Сургалтын тоо | Баруун бүсийн сургалтыг Увс аймгийн ОБГ-ын “Усны сургалт, хяналт дадлагын төв”-д зохион байгуулсан. | -2021 онд Зүүн бүсийн сургалтыг Сүхбаатар аймгийн ОБГ-т,<br>-2022 онд Өмнөд бүсийн сургалтыг Дорноговь аймгийн ОБГ-т,<br>-2023 онд Хойд бүсийн сургалтыг Булган аймгийн аймгийн ОБГ-т,<br>-2024 онд Баруун бүсийн бүсчилсэн сургалтыг Завхан аймгийн аймгийн ОБГ-т зохион байгуулна. | 2021-2024 | Улсын төсвөөс 28.0 сая төгрөг | ГШУГ, АТХХОГ, холбогдох аймгийн ОБГ, |
| | 6.7.Онцгой байдлын байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах | Мэдээллийн аюулгүй байдлын ээлэх хувь | Нийт 833 компьютерт "ESET NOD32" хорт кодын эсрэг программ суулган мэдээллийн аюулгүй байдлыг хангасан. | Онцгой байдлын байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдал 100% хангагдсан байна. | 2021-2024 | Улсын төсвөөс 200.0 сая төгрөг | ГШУГ АТХХОГ |
| | 6.8.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг чадавхжуулах, бэлэн байдлыг хангуулах | Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтын хөтөлбөр, гарын авлага | Шадар сайдын тушаалаар 2018 онд Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журам, заавар батлагдсан. | -Сайн дурын хэсгийн сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах<br>-Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалт явуулах, багаж хэрэгслээр хангах, бэлэн байдлыг хангуулах | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГУСГ, ГШУГ |
| | 6.9.Төв орон нутгийн ОББ-ын зарим ажлын байранд | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ | 2017 онд Уул уурхайн аврах ангийн алба | -2021 онд 21 аймгийн Дуудлага хүлээн авагч, жолооч холбоочин | 2021-2024 | Үйл ажиллагааны | ГШУГ, ГТТГ, |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх | хийсэн ажлын байрны тоо | хаагчдад үнэлгээ хийгдсэн. | -2022 онд аврагч-гал сөнөөгчийн /хиймчин, тэсэлгээчин, нохойчин, усчин, шүхирчин, саперчин/<br>-2023 онд Улсын нөөцийн анги салбарын ажилтан, алба хаагчдын<br>-2024 онд Эмч, эмнэлгийн зааварлагч нарын ажлын байранд үнэлгээ хийнэ. | | зардлаар | ҮАБ, ГСХ |
| **Зорилт 6.** Хөвсгөл нуурт живсэн машин, техникийг татан гаргах ажлыг олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах | 5.1. Хөвсгөл нуурт живсэн машин техникийн судалгааг хийх, тэдгээрийг татан гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах | -Живсан машин техникийн судалгаа<br>-Татан гаргасан машин техникийн тоо | - | -Нуурт живсэн машин техникийг татан гаргах бэлтгэл ажлыг хангах<br>-Нуурт живсэн машин техникийг татан гаргах ажлыг зохион байгуулах | 2021-2024 | Улсын төсөв болон Олон улсын төсөл, 50,0 тэрбум төгрөг | БОАЖЯ, ЗТЯ, ГШУГ |
| **ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 2: ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ, ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, УНТРААХ, УЛСЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг 1: Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа** | | | | | | | |
| **Зорилт 7.** Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах | 7.1.Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтыг төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт шалгалтанд хамруулах | Зөрчлийг бууруулах хувь | 615 барилга байгууламж хамрагдаж илэрсэн зөрчил 3204, арилгуулсан зөрчил 1341 | Нийт газрын тосны бүтээгдэхүүн борлуулдаг, хадгалдаг хуулийн этгээд, иргэнийг бүрэн хамруулах зөрчлийг 80% хүртэл бууруулна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГТТГ, МХЕГ, ГТХЭГ |
| | 8.1.Гал түймэртэй тэмцэх тоног төхөөрөмжийн чадавхыг нэмэгдүүлэх (Амьсгалын бие даасан тоног төхөөрөмжийн хангалт) | Амьсгалын бие даасан төхөөрөмжийн хангалтын хувь | Амьсгалын бие даасан төхөөрөмжийн хангалт улсын хэмжээнд 2395 байхаас 913 ширхэг буюу 38,1 %-ийн хангалттай байна. | 2022 онд Улсын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжийн хангалтыг 65%-д хүргэнэ. | 2021-2024 | Улсын төсөв | ГТТГ, АТХХОГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 8.** Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах | 8.2.Барилга байгууламжийн зураг төслийг хянах | Зураг төслийн хяналтын тоо | 315 барилга байгууламжийн зураг төсөл хянаж, 214 зөрчил арилгуулсан | Улсын хэмжээнд баригдахаар төлөвлөгдөж буй зураг төсөлд галын аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалт хийснээр илэрхийлэгдэнэ. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГТТГ |
| | 8.3.Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах улсын комисст ажиллах | Ашиглалтанд хүлээн авсан барилга, байгууламжийн тоо | 416 барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авсан | Байнгын ашиглалтанд оруулах барилга байгууламжийн галын аюулгүй байдал хангагдсанаар илэрхийлэгдэнэ. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГТТГ |
| | 8.4.Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажиллах журам, сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулах, сургалт явуулах | -Сайн дурын хэсгийн талаар судалгааны ажил<br>-Сургалтын хөтөлбөр<br>Сургалтын тоо | Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажиллах журам /ОБЕГ-ын даргын 2015 оны А/346 дугаар тушаал/ | -Журмыг шинэчлэн боловсруулж, Шадар сайдын тушаалаар батлуулна.<br>-Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж батлуулна. | 2022-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГТТГ, ГСХ |
| | 8.5.Аж ахуйн нэгж, байгуулагын галын аюулгүй байдлыг хангах, гал унтраах шуурхай төлөвлөгөө боловсруулах загварыг боловсруулж батлуулна. | Галын аюулгүй байдлыг хангах, гал унтраах шуурхай төлөвлөгөөний загвар | - | -Аж ахуй нэгж, байгууллагын галын аюулгүй байдал хангагдана.<br>-Байгууллага, аж ахуйн нэгжүүд гал унтраах шуурхай төлөвлөгөөтэй болно. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГТТГ |
| | 8.6.ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албатай хамтран ажиллаж төлөвлөгөө боловсруулж батлуулах, хамтран ажиллах | Хамтран ажиллаж төлөвлөгөө | ОБЕГ, ЦЕГ-ын хамтран ажиллах санамж бичиг 2018 он | -Хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж батлуулна.<br>-Хоёр байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан байна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ГТТГ, Экологийн цагдаагийн алба |
| **ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 3: ГАМШГИЙН ҮЕИЙН НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ** | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг 1: Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, нөхөн бүрдүүлэх** | | | | | | | |
| **Зорилт 9.** Стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | 9.1.Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулах" төсөл хэрэгжүүлэх | Техник, эдийн засгийн үндэслэл<br>Агуулах барих төсөл | -Агуулахын зураг төсөв 2015 онд хийгдсэн. Газар эзэмших гэрчилгээ авсан.<br>-Барилгын инженер-геологийн болон техникийн нөхцлийн | -Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, судалгаа, шинжилгээ хийнэ.<br>-Төслийн хүрээнд агуулахын цогцолбор байгуулагдана. | 2021-2024 | Олон улсын төсөл, хөтөлбөр 54,0 тэрбум төгрөг | УНХТГ, БЗХАГ, СЯ, БХБЯ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дүгнэлт хийгдсэн. | | | | |
| | 9.2.Иж бүрэн механикжуулсан махны зоорь, хүнсний агуулах байгуулах" төсөл хэрэгжүүлэх | Шинэчилсэн техник, эдийн засгийн үндэслэл<br><br>Агуулах барих төсөл | Агуулахын зураг төсөв, ТЭЗҮ 2013 онд хийгдсэн. Газар эзэмших гэрчилгээ авсан. Барилгын инженер-геологийн болон техникийн нөхцлийн дүгнэлт хийгдсэн. | -Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, судалгаа, шинжилгээ хийнэ.<br>-Техник, эдийн засгийн үндэслэл шинэчлэн боловсруулна.<br>-Төслийн хүрээнд агуулахын цогцолбор байгуулагдана. | 2021-2024 | Олон улсын төсөл, хөтөлбөр 79.7 тэрбум төгрөг | УНХТГ, БЗХАГ, СЯ, БХБЯ |
| **Зорилт 10.** Улсын нөөцийн удирдлага, зохион байгуулалт, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулалтыг сайжруулах | 10.1.Засгийн газрын 2018 оны "Улсын нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг батлах тухай" маш нууц 364 дүгээр тогтоолыг шинэчлэн батлуулах | Маш нууц тогтоол | Засгийн газрын 2018 оны "Улсын нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоох тухай" маш нууц 364 дүгээр тогтоолыг батлуулсан. | 2022-2025 онд улсын нөөцөд хуримтлуулан хадгалах нөөцийн бараа материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг тогтоож, Засгийн газрын тогтоолоор батлуулна | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | УНХТГ |
| | 10.2.Улсын нөөцөд стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх ажиллагаар зохион байгуулах | -Улсын нөөцөд бараа, материал худалдан авах жил бүрийн ерөнхий төлөвлөгөө<br>-Улсын нөөцийн нөхөн бүрдүүлэлт | Маш нууц тул суурь түвшинг илэрхийлэх боломжгүй | Батлагдсан төсвийн дагуу улсын нөөцөд бараа, материал худалдан авах жил бүрийн ерөнхий төлөвлөгөөг Шадар сайдын тушаалаар батлуулна.<br>Улсын нөөцөд стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх ажиллагаар зохион байгуулна | 2021-2024 | Улсын төсөв болон нөөцийн бараа, материалын борлуулалтын орлогоор | УНХТГ |
| | 10.3. Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед улсын нөөцөөс бараа, материал гаргах тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах | Улсын нөөцөөс бараа, материал гаргах тухай Засгийн газрын тогтоол | Засгийн газрын 2 удаагийн тогтоолоор 6.7 тэрбум төгрөгийн бараа, материал олгосон. | Засгийн газрын тогтоолын дагуу тухай бүр бараа, материалыг гаргах, нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | 2021-2024 | Улсын төсөв | УНХТГ |
| | 10.4. Төв, орон нутгийн Улсын нөөцийн анги, салбар, цэгийн нөөцийн барааны бүртгэл, | Улсын нөөцийн барааны бүртгэл, хяналтын цахим мэдээллийн сан | Улсын нөөцийн 179 дүгээр салбар нь агуулахын удирдлагын систем **VERITECH** | -Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлнэ.<br>- Төв, орон нутгийн 2 УНХТА, 2 салбар нөөцийн бараа, | 2021-2024 | Улсын төсөв | УНХТГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналтын цахим мэдээллийн сан бий болгох | | программыг нэвтрүүлсэн. | материалын бүртгэл, хяналтын автомат системтэй болсон байна. | | | |
| | 10.5.Улсын нөөцийн агуулахын чадавхыг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, аюулгүй байдлыг хангах | Засвар хийх хийх барилга, байгууламж, автодүүний тоо | 4 УНХТА, 6 салбарын агуулах, конторын барилга, ШТС, дулааны шугамын угсралтад нийт 1238.6 сая төгрөгийн засварын ажил хийгдсэн | 16 агуулахын их засвар, 8 агуулахын дээврийн засвар, 5 хашааны шинэчлэлт, газрын тосны бүтээгдэхүүний 2 агуулахын их засвар, 1000 м3-ын багтаамжтай 2 савны угсралтын ажил, 3 автопүүний их засвар, шинэчлэлтийн ажлууд хийгдэнэ. | 2021-2024 | Улсын төсөв | УНХТГ |
| **ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 4: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг 1: Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| **Зорилт 11.** Удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх | 11.1.Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах | -Архив албан хэрэг хөтлөлтийн цахим програм **(EDOC)**<br>-Өргөдөл гомдлыг шийдвэрлэх цахим програм | Архивын AMS програм, албан хэрэг хөтлөлтийн цахим бүртгэл мэдээллийн систем ашиглаж байна. | -2021 онд Архив, албан хэрэг хөтлөлтийн EDOC цахим үйлчилгээ нэвтрүүлнэ.<br>-Цахим үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах сервертэй болсон байна.<br>-Иргэд, албан хаагчаас ирүүлж буй өргөдөл гомдол цахим хэлбэрт шилжсэн байна. | 2021-2024 | 2021 онд Архивын үйлчилгээний эрхийн үнэ 1.76 сая төгрөг, 2022 онд сервер компьютер 19,0 сая төгрөг | ЗУГ |
| | 11.2.Бие бүрэлдэхүүний нөхөн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах | Хүний нөөцийн нөхөн хангалт хувь | Хүний нөөцийн нөхөн хангалт 90 хувь | -Хүний нөөцийн нөхөн хангалтыг 94 хувьд хүргэнэ. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ЗУГ, ДХИС |
| | 11.3.Бие бүрэлдэхүүний сургалт, хөгжлийг төлөвлөх, зохион байгуулах | Бие бүрэлдэхүүний давтан сургалтын тоо | Бие бүрэлдэхүүний давтан сургалтыг 59 удаа зохион байгуулсан. | -Бие бүрэлдэхүүний сургалтыг жил бүр 40-с доошгүй удаа зохион байгуулсан байна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ЗУГ, ДХИС |
| | 11.4. Дорнод, Сэлэнгэ, Баян-Өлгий, Архангай аймагт Уснаас эрэн хайх аврах ажиллагааны | Сургалт, дадлагын төвийн тоо | Усны дадлага, сургалтын төвийн тоо 3. | -Дорнод, Сэлэнгэ, Баян-Өлгий, Архангай аймагт Усны сургалт, дадлагын төвийг барьж ашиглалтад оруулна. | 2021-2024 | Орон нутгийн төсөв | ЗУГ, Аймгийн ОБГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт, дадлагын төв байгуулах | | | | | | |
| | 11.5. "Онцгой байдлын байгууллагад алба хаах журам", "Онцгой байдлын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн боловсруулах | Журам, дүрэм | МУШС-ийн 2017 оны 105 дугаар тушаал<br>ОБЕГ-ын даргын 2013 оны А/799 дүгээр тушаал | Журам, дүрмийг шинэчлэн боловсруулж Шадар сайд болон ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулна | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ЗУГ |
| | 11.6.Байгууллагын үйл ажиллагаанд олон улсын чанарын нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, нутагшуулах | Олон улсын чанарын нэгдсэн менежментийн гэрчилгээний баталгаажилтын тоо | ОБЕГ, НОБГ, 21 аймаг, 9 дүүргийн ОБГ-т нэвтрүүлж гэрчилгээ олгосон | Сургалт зохион байгуулах, сургагч багш нар бэлтгэх, жил бүр магадлан аудит хийлгэх, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нутагшуулсан байна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ЗУГ<br>Мон Сертф ТББ |
| | 11.7.Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажиллах орчин, нийгмийн баталгаа сайжруулах дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт 20 % | Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 %-д хүргэнэ. | 2021-2024 | Улсын болон нутгийн төсөв | ЗУГ, Аймаг, нийслэлийн ОБГ |
| | 11.8.Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцооны стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллаганы төлөвлөгөөг | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллаганы төлөвлөгөө 2020 он | -Стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллаганы төлөвлөгөөг жил бүр боловсруулж батлуулна. | 2021-2024 | Улсын төсөв | ЗУГ<br>АТГ |
| **Үндсэн чиг үүрэг 2: Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх** | | | | | | | |
| | 12.1.Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах | Холбогдох судалгаа, Хуулийн төсөл | Улсын нөөцийн тухай хууль, 2007 он | -Холбогдох судалгаа, нөлөөллийн үнэлгээ хийнэ.<br>-Хуулийн төсөл боловсруулж, УИХ-аар батлуулсан байна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | УНХТГ, БЗХАГ |
| | 12.2."Онцгой байдлын байгууллагыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах | Онцгой байдлын байгууллагыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр | Хөтөлбөрийн төсөл боловсруулагдсан. | Хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулж, Шадар сайдын тушаалаар батлуулна. | 2021-2022 | Үйл ажиллагааны зардлаар | БЗХАГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 12.** Гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бүх талын хамтын ажилллагаар хөгжүүлэх | 12.3.“Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгах санал, төсвийн тооцооллыг боловруулж, холбогдох газарт хүргүүлэх | “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгах санал, төсвийн тооцоо | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр | “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгах санал батлагдсан байна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | БЗХАГ |
| | 12.4.Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр гадаад хамтын ажиллагаар бэхжүүлэх | Хамтын ажиллагаатай гадаад улс орны тоо | 26 улс, 21 байгууллагатай хамтран ажиллаж байна. | Жил бүр шинээр 1-2 улс оронтой харилцаа тогтоож, Төв болон Зүүн өмнөд Ази дахь хамтын ажиллагаар хөгжүүлнэ.<br>ОХУ, БНХАУ. БНЭУ-тай харилцаагаа нэг шат ахиулна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | БЗХАГ |
| **Үндсэн чиг үүрэг 3: Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| **Зорилт 13.** Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ар тал, хангалт үйлчилгээг сайжруулах | 13.1. ОБЕГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2021-2024 оны төсвийн төслийг стратегийн зорилттой нийцүүлэн боловсруулж, Шадар сайдын ажлын алба, Сангийн яаманд хүргүүлэх | 2021-2024 оны төсвийн төсөл | ОББ-ын 117,6 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан | 2021 оны төсвийн төслийг 146.9,<br>2022 оны төсвийн төслийг 162.6,<br>2023 оны төсвийн төслийг 175.5, 2024 оны 190,4 тэрбум төгрөгөөр боловсруулж Шадар сайдын ажлын алба, СЯ-нд тус тус хүргүүлнэ. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | АТХХОГ |
| | 13.2.Шинээр байгуулагдсан Гал унтраах, аврах анги, салбаруудын барилгын хөрөнгийг шийдвэрлэх, хуучирч ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламжийг шинэчлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | Шинээр баригдсан барилга, байгууламжийн тоо | Нийт барилга байгууламжийн хувьд 30% нь 2000 оноос хойш ГТУАА-ийн барилга байгууламжийн 40% хувь нь 2000 оноос хойш баригдсан | -НОБГ-ын ГТУА 10 дугаар ангийн барилга 12,5 тэрбум төгрөг<br>-ГТУА 16-р анги 2.9 тэрбум төгрөг,<br>-ГТУА 12-р анги 2.9 тэрбум төгрөг,<br>Өвөрхангай-ЭХАС 550 сая төгрөг,<br>Их засвар 500 сая төгргөг,<br>-ГТУА 33-р анги 2.9 тэрбум төгрөг<br>-Орхон ГТУА анги 2.6 тэрбум төгрөг<br>-Ханбогд сум ГТУА анги 2.6 тэрбум<br>Өмнөговь-ЭХАС 550 сая төгрөг<br>Их засвар 500 сая төгрөг<br>- Цогтцэций ГТУА 2.6 -тэрбум төгрөг<br>-ГТУА 50-р анги 2.6 тэрбум төгрөг<br>-ГТУА 39-р анги 2.6 тэрбум төгрөг<br>-ГТУА 49-р анги 2.6 тэрбум төгрөг | 2021-2024 | Улсын төсөв 27.45 тэрбум төгрөг | АТХХОГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрэн хайх аврах салбар 550 сая төгрөг<br>Их засвар 500 сая төгрөг | | | |
| | 13.3.Аврах, гал унтраах ажиллагааны тоног төхөөрөмж болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх | Тоног төхөөрөмж болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалтын хувь | Аврах ажиллагааны тоног төхөөрөмжийн хангалт: 41,5%.<br>-Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалт: 38%<br>- Гал унтраах чиглэлийн тоног төхөөрөмжийн хангалт: 51.8% | -Аврах ажиллагааны тоног төхөөрөмжийн худалдан авалт 14.2 тэрбум төгрөг, хангалт 80 %-д,<br>-Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн худалдан авалт 12,0 тэрбум, хангалт 79%-д,<br>-Гал түймэртэй тэмцэх чиглэлээр 7.6 тэрбум, хангалт 80%-д хүрнэ. | 2021-2024 | Улсын төсөв 114,9 тэрбум төгрөг. | АТХХОГ |
| **Үндсэн чиг үүрэг 4: Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит зохион байгуулах** | | | | | | | |
| **Зорилт 14.**<br>Дотоод аюулгүй байдлыг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг дээшлүүлэх | 14.1.Бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах | Хяналт шинжилгээ үнэлгээний тайлан | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газрын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги–2030", "Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих байгаа төсөл, хөтөлбөр", Үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө", "Төрийн бодлого, "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Онцгой байдлын ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө", бодлого, хөтөлбөр зэрэг 18 бодлогын баримт бичиг | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ДХШАБГ |
| | 14.2.ОББ-ын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд үндэслэн хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх | Хяналт шинжилгээ-үнэлгээний тайлан | Хяналт шалгалт явуулах холбогдох журам, заавар, шалгуур үзүүлэлт | Жил бүр -аас доошгүй аймгийн ОБГ, 4-өөс доошгүй харьяа салбар нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулж, үнэлж дүгнэсэн байна. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ДХШАБГ |
| | 14.3.Алба хаагчдын үйл ажиллагаанд чиг үүргийн иж бүрэн шинжилгээ | Чиг үүргийн шинжилгээ хийх офицер | Хяналт шалгалт явуулах холбогдох журам, заавар, | 2021 онд офицер бүрэлдэхүүний 25%-д, | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ДХШАБГ |

| Бодлогын баримт бичигт туссан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2020/ | Зорилтот түвшин | Хугацаа он | Санхүүгийн эх үүсвэр | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, чиг үүргийг оновчтой болгох, ажил үүргийн давхцалыг арилгах | бүрэлдэхүүний эзлэх хувь | шалгуур үзүүлэлт | 2022 онд офицер бүрэлдэхүүний 50%-д,<br>2023 онд офицер бүрэлдэхүүний 75%-д,<br>2024 онд офицер бүрэлдэхүүний 100%-д хийсэн байна.. | | | |
| | 14.4. Байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, маргаанд дотоод хяналт шалгалт хийх, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах | Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн тоо | Хяналт шалгалт явуулах холбогдох журам, заавар, шалгуур үзүүлэлт | Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт 100 хувь хангагдана.<br>Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны аргачлал, зааврыг боловсонгуй болно. | 2021-2024 | Үйл ажиллагааны зардлаар | ДХШАБГ |

## НАЙМ. НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

### 8.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо



## 8.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт

### 1.Онцгой байдлын ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт




### 2. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллагууд



# ЕС. ХАВСРАЛТ

## 9.1. Онцгой байдлын ерөнхий 2021-2024 оны төсвийн төсөөлөл

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он |
| 1 | Онцгой байдлын байгууллага | Сая.төг | 146,942.8 | 162,600.0 | 175,545.3 | 190,420.6 |
| | **Урсгал зардлын дүн:** | | **119,587.8** | **127,266.8** | **130,045.3** | **136,670.6** |
| | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 69,766.6 | 72,708.4 | 74,705.5 | 78,480.6 |
| | Бараа, үйлчилгээний зардал | | 41,095.7 | 45,758.4 | 46,489.8 | 49,290.0 |
| | Татаас ба урсгал шилжүүлэг | | 8,725.4 | 8,800.0 | 8,850.0 | 8,900.0 |
| | **Хөрөнгийн зардлын дүн:** | | **27,355.0** | **35,333.2** | **45,500.0** | **53,750.0** |
| | Барилга байгууламж | | 12,675,4 | 6,350.0 | 8,650.0 | 10,950.0 |
| | Их засвар | | - | 500.0 | 500.0 | 500.0 |
| | Тоног төхөөрөмж | | 100.0 | 20,383.2 | 18,650.0 | 33,800.0 |
| | 2.Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх | | 8,079.6 | 8,100.0 | 8,200.0 | 8,500.0 |
| | 3.Бусад хөрөнгө /машин техник/ | | 6,500.0 | - | 9,500.0 | - |

----oOo----

### 9.2. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд нийтлэг мөрдөгдөж байгаа хууль

| № | Монгол Улсын хуулиуд | Батлагдсан он |
|---|---|---|
| 1. | Гамшгаас хамгаалах тухай хууль | 2017 |
| 2. | Галын аюулгүй байдлыг хангах тухай хууль | 2015 |
| 3. | Улсын нөөцийн тухай хууль | 2007 |
| 4. | Төрийн албаны тухай хууль | 2017 |
| 5. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль | 1995 |
| 6. | Хөдөлмөрийн тухай хууль | 1999 |
| 7. | Төрийн хяналт шалгалтын тухай хууль | 2003 |
| 8. | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль | 2004 |
| 9. | Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа , материал худалдан авах тухай хууль | 2005 |
| 10. | Авилгын эсрэг тухай хууль | 2006 |
| 11. | Төсвийн тухай хууль | 2011 |
| 12. | Захиргааны ерөнхий хууль | 2015 |
| 13. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | 2015 |
| 14. | Цэргийн албаны тухай хууль | 2016 |
| 15. | Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль | 2016 |
| 16. | Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай | 2016 |
| 17. | Барилгын тухай хууль | 2016 |
| 18. | Төрийн болон албаны нууцын тухай хууль | 2016 |
| 19. | Зөрчлийн тухай хууль | 2017 |
| 20. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль | 2017 |
| 21. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль | 2020 |

## 9.3. Онцгой байдлын байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагаа

### 1.Төрийн захиргааны байгууллагууд

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Санамж бичиг | 2018 | 2025 |
| 2. | ЗТХЯ-ны харьяа Далайн захиргаа | Санамж бичиг, төлөвлөгөө | 2020 | 2025 |
| 3. | БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв | Санамж бичиг | 2020 | 2021 |
| 4. | Иргэний нисэхийн ерөнхий газар | Санамж бичиг | 2020 | 2022 |
| 5. | Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар | Гэрээ, мэдээлэл солилцох жагсаалт | 2019 | 2020 |
| 6. | ЭМЯ-ны харьяа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв | Санамж бичиг | 2019 | 2022 |
| 7. | Дотоод хэргийн их сургууль | Санамж бичиг | 2018 | 2023 |
| 8. | Үндэсний статистикийн хороо | Санамж бичиг | 2019 | 2022 |
| 9. | Монголын үндэсний олон нийтийн радио телевиз | Санамж бичиг | 2016 | - |
| 10. | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар | Санамж бичиг | 2017 | - |
| 11. | Цагдаагийн ерөнхий газар | Санамж бичиг | 2018 | 2021 |
| 12. | Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд | Онцгой нөхцөл байдал үүссэн үед Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллага, Тагнуулын ерөнхий газар, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харилцан ажиллагааг зохицуулах чиглэлийн төлөвлөгөө /Нууц/ | 2016 | - |

### 2.Төрийн өмчит хуулийн этгээд

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны хэлбэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | Оюу толгой ХХК | Санамж бичиг | 2019 | 2021 |
| 2. | Эрдэнэт ТӨҮГ | Гэрээ | 2003 | |

### 3.Олон улсын байгууллага

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны хэлбэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар | Хамтарсан мэдэгдэл | 2018 | Хугацаа дууссан |
| 2. | НҮБ-ын Хүн амын сан | Гэрээ | 2016 | Хугацаа дууссан |
| 3. | Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ | Санамж бичиг | 2010 | - |
| 4. | БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллаа /КОЙКА/ | Санамж бичиг | 2014 | Хугацаа дууссан |
| 5. | Тайландын Хаант Улсын Үндэсний телевиз, Азийн гамшгийн бэлэн байдлын төв | Санамж бичиг | 2018 | Хугацаа дууссан |
| 6. | Азийн гамшгийн бэлэн байдлын төв | Санамж бичиг | 2016 | - |
| 7. | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр | Санамж бичиг | 2013.09 | Хугацаа дууссан |
| 8. | Японы хүүхдийг ивээх сан | Санамж бичиг, Төлөвлөгөө | 2018 | 2021 |
| 9. | Мерси Кор олон улсын байгууллага | Санамж бичиг | 2017 | 2018 |
| 10. | “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага | Санамж бичиг | 2015 | 2018 |
| 11. | “Каритас Монгол” олон улсын байгууллага | Санамж бичиг | 2019 | 2020 |
| 12. | Ази номхон далайн бүс нутгийн түншлэл судалгааны төв | Санамж бичиг | 2016 | 2019 |

## 4.Гадаад улсын байгууллага

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны хэлбэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | Оросын Холбооны Улс | Засгийн газар хоорондын хэлэлцээр | 1995 | - |
| 2. | Бүгд Найрамдах Хятад Ард Улс | Засгийн газар хоорондын хэлэлцээр | 1999 | - |
| 3. | Бүгд Найрамдах Казахстан Улс | Засгийн газар хоорондын хэлэлцээр | 2007 | - |
| 4. | Бүгд Найрамдах Беларусь Улс | Засгийн газар хоорондын хэлэлцээр | 2019 | - |
| 5. | Бүгд Найрамдах Франц Улс | Засгийн газар хоорондын хэлэлцээр | 2020 | - |
| 6. | АНУ-ын Аляск муж улсын Үндэсний гварди | Санамж бичиг | 2003 | - |
| 7. | АНУ-ын Засгийн газрын Төрийн департмент | Санамж бичиг | 2020 | - |
| 8. | Австрали Улсын Улсын Улаан Загалмай нийгэмлэг | Санамж бичиг | 2011 | 2016 |
| 9. | Австри Улсын “Розенбаур Интернейшнл АГ” компани | Хамтран ажиллах гэрээ | 2014 | - |
| 10. | БНСВУ-ын Улсын Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яам | Санамж бичиг | 2018 | - |
| 11. | Бүгд Найрамдах Киргиз Улсын Онцгой байдлын яам | Санамж бичиг | 2016 | - |
| 12. | БНАСАУ-ын Онцгой байдал, гамшгийн удирдлагын улсын хороо | Санамж бичиг | 2018 | - |
| 13. | БНСУ-ын Онцгой байдлын ерөнхий газар | Санамж бичиг | 2006 | - |
| 14. | БНСУ-ын Үндэсний аврах алба-119 | Санамж бичиг | 2012 | - |
| 15. | БНСУ-ын “Чангвон” коллеж | Санамж бичиг | 2009 | - |
| 16. | БНСУ-ын “Чангшин их сургууль”, Чанвон хотын Галын газар | Санамж бичиг | 2020 | - |
| 17. | БНСУ-ын “Эй Энд Ди Инженеринг” ХХК | Хамтран ажиллах гэрээ | 2014 | - |
| 18. | Бүгд Найрамдах Беларусь Улс “Пожснаб” компани | Гэрээ | 2019 | 2020 |
| 19. | БНТУ-ын Гамшиг, онцгой байдлын удирдлагын газар | Санамж бичиг | 2018 | - |
| 20. | БНФУ-ын “Десотел САС” компани | Гэрээ | 2020 | - |
| 21. | БНФУ-ын “Хэли Юнион” компани | Гэрээ | 2020 | - |
| 22. | БНЭУ-ын Үндэсний гамшгийн удирдлагын газар | Санамж бичиг | 2019 | - |
| 23. | Унгар Улсын Гамшгийн удирдлагын ерөнхий газар | Санамж бичиг | 2019 | - |
| 24. | Япон Улсын Агаарын орон зайн судалгааны агентлаг | Санамж бичиг | 2010 | 2013 |
| 25. | Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ | Гэрээ | 2012 | 2014 |

## 5. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны хэлбэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | Шинжлэх ухааны академи | Санамж бичиг, Төлөвлөгөө | 2016 | 2019 |
| 2. | БШУЯ, Технологийн бодлогын газар | Төсөл хэрэгжүүлэх гэрээ | 2018 | - |
| 3. | Шинжлэх ухаан технологийн сан | Төсөл хэрэгжүүлэх санхүүжүүлэх гэрээ | 2018 | - |
| 4. | Физик технологийн хүрээлэн | Санамж бичиг | 2020 | - |
| 5. | Одон орон геофизикийн хүрээлэн | Хамтран ажиллах гэрээ | 2019 | - |
| 6. | Геонэт ХХК | Хамтран ажиллах гэрээ | 2018 | - |
| 7. | Эс Эф Си Эс ХХК | Хамтран ажиллах гэрээ | 2019 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. | Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний үндэсний төв | Санамж бичиг | 2015 | 2018 |
| 9. | БНСУ-ын Галын хүрээлэн | Санамж бичиг | 2017 | - |
| 10. | БНСУ-ын “Мурим” компани | Санамж бичиг | 2013 | - |
| 11. | ОХУ-ын Красноярскийн Газар тариалангийн их сургууль | Хамтын ажиллагааны протокол | 2019 | - |
| 12. | Шинэ Зеланд Улсын Хойд Палмерстоны Массигийн Их Сургууль, Гамшиг судлалын хамтарсан төв | Санамж бичиг | 2019 | - |

## 6. Хувийн хэвшлийн байгууллагууд

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны хэлбэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | Риск Энвайрон ХХК | Санамж бичиг | 2019 | 2021 |
| 2. | What3words ХХК | Санамж бичиг | 2020 | 2023 |
| 3. | Эс Эс Ай Эм Эн ХХК | Санамж бичиг | 2017 | 2018 |
| 4. | Тэкол ХХК | Санамж бичиг, төлөвлөгөө | 2015 | 2018 |
| 5. | Шинэболд ХХК | Санамж бичиг, төлөвлөгөө | 2015 | 2018 |
| 6. | Буман девелопмент ХХК | Санамж бичиг | 2015 | 2018 |
| 7. | Гео-Информэшн сольюшнс ХХК | Санамж бичиг | 2015 | 2018 |
| 8. | Дат-Консалтинг ХХК | Санамж бичиг | 2017 | 2018 |
| 9. | Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим | Санамж бичиг | 2020 | 2023 |

## 7.Иргэний нийгмийн болон олон нийтийн байгууллагууд

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны хэлбэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | Монголын улаан загалмайн нийгэмлэг | Санамж бичиг | 2020 | 2025 |
| 2. | Гамшгийн эсрэг үндэсний төв | Санамж бичиг, төлөвлөгөө | 2018 | - |
| 3. | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо | Санамж бичиг, төлөвлөгөө | 2019 | 2022 |
| 4. | Монголын байгаль орчин, аюулгүй байдлын төв | Санамж бичиг | 2019 | 2022 |
| 5. | Монголын даатгалын холбоо | Санамж бичиг | 2019 | 2020 |
| 6. | Чинагийн Галсан сан | Санамж бичиг | 2019 | 2021 |
| 7. | “Менежмент ба ур чадварын хүрээлэн” | Санамж бичиг | 2020 | 2025 |
| 8. | Гамшиг, гал түймрээс хамгаалах Монголын нийгэмлэг | Санамж бичиг | 2017 | 2019 |
| 9. | Оргил өөд клуб | Санамж бичиг | 2015 | 2016 |
| 10. | Гамшгаас хамгаалах Үүрд тэгш нийгэмлэг | Санамж бичиг | 2015 | 2018 |
| 11. | Монголын галын инженер техникчдийн холбоо | Санамж бичиг, төлөвлөгөө | 2015 | - |

### 9.4. Онцгой байдлын байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээ

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон энэхүү стратегид дэвшүүлсэн зорилт, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг дараахь байдлаар тодорхойлов.

| **Нэг. Гадаад орчны шинжилгээ** |
| --- |
| **1. Улс төрийн орчин** |
| • 2020 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулиар Монгол Ардын Нам олонх болсоноор УИХ, Засгийн газрын тогтвортой, үйл ажиллагааны нэгдмэл байдал хангагдсан нь байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байна.<br>• Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 4 дүгээр тогтоолоор Онцгой байдлын байгууллагыг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтаасан бөгөөд аливаа асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэхэд шат дамжлага бага гардаг.<br>• Төрийн байгууллагыг улс төрөөс хараат байдлыг багасгах, төрийн албаны тогтвортой, мэргэшсэн байдлыг хангах асуудлыг 2017 онд шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулиар баталгаажуулсан.<br>• Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан Улсын онцгой комисс, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай зөвлөлийг, орон нутагт Засаг даргаар ахлуулсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл ажилладаг.<br>• Гамшгаас хамгаалах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч болон УИХ, Засгийн газрын зүгээс чухалчлан авч үзэж, зохих шийдвэрүүдийг гаргаж ажилладаг. |
| **2. Эдийн засгийн орчин** |
| • Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс гадна олон улсын зээл, тусламж, Засгийн газрын нөөц хөрөнгө зэрэг эх үүсвэрээс санхүүжүүлдэг.<br>• Гамшгаас хамгаалах тухай хуулинд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэр, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан. Гэвч энэхүү хуулийн хэрэгжилт хангалтгүй байдаг.<br>• Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөд тодорхой хэмжээний зардал суулгадаг бөгөөд Сангийн сайдын 2019 оны 318 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг баталсан.<br>• Улс орны эдийн засгийн чадавх сул, төсвийн хөрөнгө мөнгө хязгаарлагдмал тул гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулах зардал бага байдаг.<br>• Улс орны эдийн засгийн нөөцийн баталгаа, тогтвортой, найдвартай байдал сул тул томоохон хэмжээний гамшиг тохиолдсон үед улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал хүндрэх магадлалтай.<br>• Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр тусдаа сан байхгүй тул гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг Засгийн газрын нөөц хөрөнгөөс /энэ нь хязгаарлагдмал нөөцтэй/ санхүүжүүлдэг<br>• Эдийн засаг, төсөв санхүүгийн байдлаас шалтгаалж, гамшгаас хамгаалах чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөр хагас дутуу хэрэгждэг. |

| 4. Нийгэм, соёлын орчин |
|---|
| • Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн тогтолцоо бүрдсэн.<br>• Онцгой байдлын байгууллага болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагаас орон нутгийн удирдлага, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, дадлагыг дээшлүүлэх чиглэлээр жил бүр тогтол сургалт, сурталчилгааг зохион байгуулдаг. Тухайлбал: Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу жилд дунджаар удирдах албан тушаалтны сургалтыг 70 гаруй, оюутан, сурагчдын сургалтыг 100 гаруй, албан тушаалтан, ажилтны сургалтыг 500 гаруй, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалтыг 200 гаруй, иргэдийн сургалтыг 260 гаруй удаа, гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 1-2 аймагт, гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 3-4 аймагт зохион байгуулдаг.<br>• Хот суурин газрын хэт төвлөрөл, замбараагүй газар төлөвлөлт, хүн амын тоо өсөн нэмэгдэж байгаа нь гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ялангуяа нийслэл хотод Монгол Улсын хүн амын тал орчим хувь нь амьдарч байгаа бөгөөд улсын хэмжээнд сүүлийн 5 жилд тохиолдсон гамшиг, ослын дуудлагын 57.9 хувь нь нийслэл хотод тохиолдсон байна[1].<br>• Хүн амын ихэнх хувь нь амьжиргааны дундаж түвшингээс доогуур, ажилгүйдэл, ядуурлын түвшин, эмзэг бүлгийхний эзлэх хувь өсөж байгаа нь гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. 2019 оны байдлаар хотын нийт хүн амын 27.2 хувь, хөдөөгийн хүн амын 30.8 хувь нь ядуу байгаа бөгөөд Улаанбаатар хотод хамгийн олон буюу 378.2 мянган хүн Өмнөговь аймагт хамгийн бага буюу 8.2 мянган хүн ядууралд орсон байна. 2019 оны дүнгээр Монгол Улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4317 ам доллар байна. 2020 оны 9 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй хүний тоо 17.8 мянга хүрсэн.[2]<br>• Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хувийн хэвшлийнхний оролцоо, нийгмийн хамгаалал, гамшгаас хамгаалах даатгалын тогтолцоо хангалтгүй байгаа нь төрд үзүүлэх ачааллыг нэмэгдүүлж байна.<br>• Гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн идэвх оролцоо сул, мэдлэг бага, нийслэл, аймаг, сум, дүүргийн онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн чадавх, үйл ажиллагаа харилцан адилгүй байна. |
| **4. Технологийн орчин** |
| • Гамшгийн үеийн мэдээ, мэдээллийг улсын хэмжээнд түргэн, шуурхай солилцох систем бүрдсэн.<br>• Засгийн газраас төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор технологийн дэвшлийг ашиглах үйл явцыг бодлогоор дэмжиж байна.<br>• Техник, технологийн хөгжлөөс үүдэн уламжлалт бус гамшиг, ослын тоо нэмэгдэх хандлагатай байгаа.<br>• Төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх боломж бага.<br>• Гамшгийн аюулаас эрт зарлан мэдээлэх тогтолцоо төдийлөн сайн хөгжөөгүй. |
| **5. Хууль эрх зүйн орчин** |
| • Галын аюулгүй байдлын тухай хуулийг 2015 онд, Гамшгаас хамгаалах хуулийг 2017 шинэчлэн баталж, 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулсанаар гамшгаас хамгаалах эрх зүйн орчин харьцангуй боловсронгуй болсон.<br>• Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохицуулж байгаа үндсэн 3 хууль, нийтлэг мөрдөж байгаа 30 гаруй хууль, УИХ, Засгийн газар, Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан 100 гаруй дүрэм, журам, заавар батлагдсан. |

[1] Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг, ослын дүн мэдээ.
[2] Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

| |
|---|
| • Гамшгаас хамгаалах салбараас бусад 50 гаруй хуулинд гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой асуудал туссан.<br>• Гамшгаас хамгаалах хууль, тогтоомж хангалттай хэрэгжиж байгаа боловч, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр батлагдсан бодлого, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалт, хүсэл сонирхол хангалттай бус байна.<br>• Гамшгаас хамгаалах даатгалын тогтолцоо, эрх зүйн орчин бүрдээгүй байна.<br>• Улсын нөөцийн тухай хуулийг боловсронгуй болгох шаардлага байгаа. |
| **6. Байгаль орчин** |
| • Хот суурин газар болон хөдөөгийн хүн амын хувьд байгаль цаг, агаарын төлөв байдлыг урьдчилан мэдэх боломж бүрдсэн.<br>• Байгаль, цаг агаарын хувьд эрс тэс уур амьсгалтай, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн төрөл бүрийн гамшгийн аюул, учруулах хохирол жил тутам ихсэж байгаа.<br>• Нийт өрхийн 19.2 хувь нь мал аж ахуй, 2.0 хувь нь газар тариалан эрхэлж, байгаль, цаг уурын нөхцөл байдлаас хамааралтай амьдарч байна.<br>• Малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн даацын хүрэлцээгүй байдал, малчдын мэдлэг, мэдээлэл дутмаг байдал нь гамшгийн эмзэг байдлыг бий болгож байна.<br>• Жил бүр ой, хээрийн түймэр, үер усны аюул, ган, зуд, хүчтэй салхи шуурга зэрэг байгалийн аюулт үзэгдлээс шалтгаалан жилд дунджаар 100 гаруй хүн амь насаа алдаж, улс, нийгэмд 50 гаруй тэрбум төгрөгийн хохирол учирч байна.<br>• Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн тоо, давтамж, чичирхийллийн хэмжээ эрс нэмэгдэж байгаа. |

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон энэхүү стратегид дэвшүүлсэн зорилт, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд бусад салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, соёл, нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл) хийгээд технологийн үйл явцын давуу болон сул талыг дараахь байдлаар тодорхойлов.

| **Хоёр. Дотоод орчны нөлөөлөл** |
|---|
| **1. Бусад салбар болон засаг захиргааны нэгжийн хүрээнд** |
| • Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоолоор Засгийн газрын яам, агентлагийг түшиглэн Гамшгаас хамгаалах улсын албадыг, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжаар гамшгаас хамгаалах орон нутгийн албадыг байгуулж ажиллаж байна.<br>• Онцгой байдлын байгууллага нь Засгийн газрын яам, агентлаг, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албад хооронд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж, хамтран ажилладаг.<br>• Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий Улсын Онцгой комисс, аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон нутгийн онцгой комисс ажилладаг бөгөөд Засгийн газрын 2020 оны 02 дугаар тогтоолоор Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.<br>• Гамшгаас хамгаалах чиглэлээр 12 төрийн, 11 төрийн бус, 12 олон улсын байгууллага, 17 гадаад улс, гадаад, дотоодын 12 эрдэм шинжилгээний байгууллага, 9 хувийн хэвшлийн байгууллагатай санамж бичиг, гэрээний хүрээнд хамтран ажилладаг.<br>• Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг баруун, зүүн, хойд, өмнөд, Улаанбаатарын гэсэн 5 бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулдаг.<br>• Сонгуулийн үр дүнгээс шалтгаалан Засаг, захиргааны нэгж болон төрийн байгууллагын |

удирдлагын тогтвортой байдал алдагддаг.

- Бусад салбарууд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг Онцгой байдлын байгууллагын чиг үүрэг гэж ханддаг.
- 330 сумаас 264 сумандонцгой байдлын байгууллагын салбар нэгж байхгүй байгаа нь төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх боломж хязгаарлагдмал байна.

**2. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд**

- Засгийн газрын тохируулагч агентлагийн хувьд бүтэц, орон тоог Засгийн газраас тогтоож өгдөг.
- Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 88 дугаар тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр баталж, газар, нэгжийн чиг үүргийг тодорхойлсон.
- Онцгой байдлын байгууллагын бүтцэд Үндэсний аврах бригад, Агаараас эрэн хайх, аврах анги, Уул уурхайн аврах, Давтан сургалт, сэргээн заслын төв, Ар талын анги, Эрэлч нохойн сургалтын төв, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв, Гамшиг судлалын хүрээлэн, “Аврагч” биеийн тамир, техник-спортын хороо, Тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв, хүнс, бараа матриал, шатахууны улсын нөөцийн ангиуд, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой байдлын газар, хэлтэс, гал унтраах, аврах анги, салбар бүлэг үйл ажиллагаа явуулдаг.
- Засаг захиргааны нэгж буюу 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг, 66 суманд Онцгой байдлын байгууллагын салбар нэгж байдаг.
- Байгуулагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн шинжилгээ хийх, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлага байгаа.

**3. Байгууллагын соёл, нөөц**

- Гамшгаас хамгаалах тухай хууль болон Цэргийн албаны тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар байгууллагын болон алба хаагчийн эрх, үүргийг тодорхойлсон.
- Төрийн цэргийн байгууллагын хувьд өдөр тутмын дотоод үйл ажиллагаа нь Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмээр зохицуулагддаг.
- Хүний нөөцийн нөхөн хангалт тодорхой хэмжээнд хийгдэж мэргэжлийн боловсон хүчнээр зохих түвшинд хангагдсан.
- 2012 оноос хойш ДХИС-ийн харьяа Онцгой байдлын сургуульд гамшгаас хамгаалах мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэж байна.
- Жил бүр гадаад, дотоодод богино хугацааны давтан болон магистр, докторын сургалтад албан хаагчдыг сургаж боловсон хүчнээ мэргэшүүлдэг.
- Салбар нэгж бүрт Ёс зүйн алба ажиллаж, алба хаагчдыг аливаа гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг.
- 2020 оноос эхлэн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо ISO 45001:2018” олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.
- Төрийн байгууллагын хувьд үйл ажиллагаа нь төсвийн хөрөнгөөр санхүүждэг бөгөөд жил бүрийн төсөв тодорхой хэмжээнд нэмэгдэж байгаа.
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн төсвөөс гадна олон улсын төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлдэг.
- Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмжийн хангалт дутагдалтай. Тухайлбал: Гал түймэр, гамшигтай тэмцэх автомашин техникийн нөхөн хангалт 51.8 хувь, эрэн хайх, аврах ажиллагааны тоног төхөөрөмжийн хангалт 41.5 хувь, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалт 38 хувьтай байна.
- Хүний нөөцийг чадавхжуулах, ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах шаардлага байгаа.

| 4. Технологийн үйл явц |
| --- |
| • Хүний нөөцийн цахим бүртгэлийн систем, цахим албан хэрэг хөтлөлт, архивын систем, гамшгийн орон зайн мэдээллийн систем, байгалийн гамшгийн эрсдэлийн мониторингийн систем, газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем, байршил тодорхойлогч 3 үгт систем, иргэдийн гар утсанд цаг агаарын мэдээллийг хүргэх багц мессеж зэрэг системийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>• Олон улсын төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж байна.<br>• ОБЕГ-ын даргын 2017.12.21-ний А/334 тушаалаар “Онцгой байдлын байгууллагын инновацийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна.<br>• Алба хаагч, ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацын мэдлэгийг сайжруулах, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг дэвшүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг дэмжих орчныг бүрдүүлж, байгууллагын ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор ОБЕГ-ын даргын 2020 оны А/292 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2020 онд алба хаагчдаас нийт 152 шинэлэг санаа бүхий шинэ бүтээл, оновчтой санал гаргасан байна.<br>• Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр байгууллагын цахим хаяг болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээ, мэдээллийг тогтмол хүргэдэг.<br>• Байгууллагын дотоод үйл ажиллагааг цахимжуулах, тухайлбал, өргөдөл, гомдол, архив, албан хэрэг хөтлөлт, галын аюулгүй байдлын дүгнэлт, тусгай зөвшөөрөл зэрэг үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх шаардлага байгаа.<br>• Алба хаагчдын мэдээллийн технологийн техник хэрэгслийг шинэчлэх, цахим, аюулгүй байдлыг хангах шаардлага байгаа.<br>• Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага байгаа.<br>• Улсын нөөцийн бараа, материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлага байгаа. |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

| | |
|---|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| АТХХОГ | Ар тал, хангалт, хөрөнгө оруулалтын газар |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БЗХАГ | Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газар |
| БНАСУ | Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс |
| БНСВУ | Бүгд Найрамдах Социалист Ветьнам Улс |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| БНПУ | Бүгд Найрамдах Польш Улс |
| БНТУ | Бүгд Найрамдах Турк Улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БНФУ | Бүгд Найрамдах Франц Улс |
| БНЭУ | Бүгд Найрамдах Энэтхэг Улс |
| БТТСХ | Биеийн тамир, техник спортын хороо |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| ГСХ | Гамшиг судлалын хүрээлэн |
| ГТУАА | Гал түймэр унтраах аврах анги |
| ГТТГ | Гал түймэртэй тэмцэх газар |
| ГХУА | Гамшгаас хамгаалах улсын алба |
| ГШУГ | Гамшгийн шуурхай удирдлагын газар |
| ГУСГ | Гамшгаас урьдчилан сэргийлэх газар |
| ГЭУГ | Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар |
| ДХИС | Дотоод хэргийн их сургууль |
| ДХШАБГ | Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар |
| ЗТХЯ | Зам тээврийн хөгжлийн яам |
| ЗУГ | Захиргааны удирдлагын газар |
| МУШС | Монгол Улсын Шадар сайд |
| НОБГ | Нийслэлийн Онцгой байдлын газар |
| НҮБ | Нэгдсэн Үндэстний байгууллага |
| ОББ | Онцгой байдлын байгууллага |
| ОБГ | Онцгой байдлын газар |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТЭЗҮ | Техник, эдийн засгийн үндэслэл |
| УИХ | Улсын Их Хурал |
| УНХТГ | Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар |
| УНХТА | Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги |
| УУАА | Уул урхайн аврах анги |
| ҮАБ | Үндэсний аврах бригад |
| ХХК | Хариуцлагатай хувьцаат компани |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |